



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 26/04

Арвайхээр сум

Г

Г

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/02 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6 дугаар бүлгийн 6.4.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Тарагт сумын Туяа багийн Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй болсон 1,368,000 (нэг сая гурван зуун жаран найман мянга) төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй хөрөнгө (модон хашаа)-ийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдан борлуулсугай.
- Хөрөнгийг хууль, журамд заасны дагуу худалдан борлуулж, данснаас хасах, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэхийг Туяа багийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Д.Ууганбаяр)-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нинжбадгар)-т тус тус даалгасугай.

ДАРГА

О.ПУРЭВДОРЖ

